НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/559/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn<br>Аудитор: Д.Эрдэнэбулган<br>Утас: 325093 Цахим хаяг: erdenebulgand@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-25 № 183

танай ______________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ПҮРЭВДОРЖ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс 28.3 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 81.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 77.8 сая төгрөг, нийт 187.4 сая төгрөг эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1429 дүгээр захирамжаар 57.9 сая төгрөгийн, Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/76 дугаар захирамжаар 44.0 сая төгрөгийн 6 нэр төрлийн нийт 101.9 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

1426050293

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

***/төгрөгөөр/***

| Данс | Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|
| 34 | УРЬДЧИЛГАА | | 6,970,000.00 | | |
| 346 | Урьдчилж гарсан зардал | | 6,970,000.00 | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6 | 1,148,988,788.25 | 1,117,757,489.51 | |
| 351 | Түүхий эд материал | | 706,196,533.92 | 1,002,550,370.18 | |
| 3511 | Тусгай зориулалттай материал | | 702,723,333.92 | 1,001,950,870.18 | |
| 3513 | Эм боох материал | | 3,473,200.00 | 599,500.00 | |
| 353 | Бэлэн бүтээгдэхүүн | | 324,675,324.50 | | |
| 354 | Хангамжийн материал | | 118,116,929.83 | 115,207,119.33 | |
| 3541 | Бичиг хэргийн материал | | 4,301,510.00 | 2,798,470.00 | |
| 3542 | Аж ахуйн материал | | 1,893,200.00 | 2,013,200.00 | |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | | 18,260,952.00 | 21,028,322.00 | |
| 3544 | Түлш, шатах тослох материал | | 17,380,477.25 | 9,887,197.55 | |
| 3547 | Бусад хангамжийн материал | | 76,280,790.58 | 79,479,929.78 | |
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,155,958,788.25 | 1,117,757,489.51 | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7 | 5,071,822,318.22 | 4,237,633,301.63 | |
| 392 | Биет хөрөнгө | | 4,961,636,198.26 | 4,128,269,681.63 | |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 3,053,911,285.14 | 3,053,911,285.14 | |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | -611,442,886.62 | -727,589,875.85 | |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 4,703,241,242.44 | 4,761,129,607.44 | |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | -2,352,746,197.83 | -3,115,723,743.81 | |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 341,017,907.20 | 430,127,907.20 | |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | -187,906,466.56 | -280,434,841.69 | |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 125,065,115.00 | 125,065,115.00 | |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | -109,503,800.51 | -118,215,771.80 | |
| 393 | Биет бус хөрөнгө | | 110,186,119.96 | 109,363,620.00 | |
| 39301 | Програм хангамж | | 1,645,000.00 | 1,645,000.00 | |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | -822,500.04 | -1,645,000.00 | |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 109,363,620.00 | 109,363,620.00 | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 5,071,822,318.22 | 4,237,633,301.63 | |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 6,227,781,106.47 | 5,355,390,791.14 | |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9 | | 22,510,276.94 | |
| 413 | Өглөг | | | 22,510,276.94 | |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | | 22,510,276.94 | |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | | 22,510,276.94 | |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 6,227,781,106.47 | 5,332,880,514.20 | |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 509,506,709.69 | 509,506,709.69 | |
| 51101 | Өмч: - төрийн | | 509,506,709.69 | 509,506,709.69 | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | | 5,318,263,906.00 | 4,423,363,313.73 | |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | | 5,318,263,906.00 | 5,318,263,906.00 | |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | | -894,900,592.27 | |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 400,010,490.78 | 400,010,490.78 | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 6,227,781,106.47 | 5,332,880,514.20 | |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 6,227,781,106.47 | 5,355,390,791.14 | |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***/төгрөгөөр/***

| Данс | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 3,037,539,088.30 | 3,636,066,645.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | 2,926,971,100.00 | 3,448,720,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 2,926,971,100.00 | 3,448,720,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 110,567,988.30 | 187,346,345.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 47,471,400.00 | 28,299,290.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 44,690,000.00 | 81,230,390.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 18,406,588.30 | 77,816,665.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 566,102,703.80 | 776,429,315.81 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 566,102,703.80 | 776,429,315.81 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 30,000,000.00 | 65,773,121.55 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 30,000,000.00 | 65,773,121.55 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 72,497,000.00 | 45,100,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 463,605,703.80 | 665,556,194.26 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2 | 3,603,641,792.10 | 4,412,495,960.81 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 4,124,425,360.49 | 5,307,396,553.08 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 4,053,049,923.40 | 5,302,166,053.08 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 2,475,327,443.06 | 3,001,087,330.02 |
| 210101 | Үндсэн цалин | | 2,321,232,744.61 | 1,754,388,671.54 |
| 210102 | Нэмэгдэл | | 145,927,698.45 | 1,137,066,685.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 8,167,000.00 | 48,121,773.00 |
| 210104 | Урамшуулал | | | 61,510,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 56,134,346.60 | 60,487,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 5,390,598.86 | 253,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 634,188.46 | 29,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 388,260.05 | 17,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 245,927.33 | 6,518,515.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 49,475,371.90 | 53,668,384.08 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 193,919,318.55 | 218,286,102.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 38,772,189.25 | 53,088,343.08 |
| 210302 | Түлш, халаалт | | 139,845,837.00 | 144,922,305.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 15,301,292.30 | 20,275,454.84 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 167,820,745.01 | 98,803,027.05 |
| 210401 | Бичиг хэрэг | | 6,370,030.00 | 5,755,390.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 75,441,529.90 | 84,893,126.25 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,173,300.00 | 1,187,350.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | | | 2,024,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,200,000.00 | 1,320,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 8,074,000.00 | 3,623,160.80 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 75,561,885.11 | |
| 2105 | Нормативт зардал | | 109,469,200.00 | 776,693,663.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 137,800.00 | 2,873,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 109,331,400.00 | 137,439,872.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | | 636,380,091.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 27,241,000.00 | 63,719,456.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | 1,570,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 27,241,000.00 | 62,149,456.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 40,811,329.00 | 95,726,292.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 36,916,800.00 | 89,784,318.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 966,639.00 | 3,931,786.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 495,000.00 | 495,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,560,100.00 | 642,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 872,790.00 | 872,788.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 982,326,541.18 | 987,362,381.59 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | 125,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | | 6,050,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 982,326,541.18 | 981,187,381.59 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 71,375,437.09 | 5,230,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 5,523,100.00 | 5,230,500.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | | 3,930,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 5,523,100.00 | 1,300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 65,852,337.09 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 62,562,328.09 | |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,290,009.00 | |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3 | 4,124,425,360.49 | 5,307,396,553.08 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | | -520,783,568.39 | -894,900,592.27 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 52,807,691.60 | |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | | 52,807,691.60 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -52,807,691.60 | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | | -573,591,259.99 | -894,900,592.27 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***/төгрөгөөр/***

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,062,194,801.30 | 3,636,066,645.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,062,194,801.30 | 3,636,066,645.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,926,971,100.00 | 3,448,720,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,926,971,100.00 | 3,448,720,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 135,223,701.30 | 187,346,345.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,471,400.00 | 28,299,290.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 44,690,000.00 | 81,230,390.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 43,062,301.30 | 77,816,665.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,035,234,801.30 | 3,595,011,645.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,035,234,801.30 | 3,595,011,645.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,963,859,364.21 | 3,589,781,145.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,478,745,012.66 | 2,978,577,053.08 |
| 210101 | Үндсэн цалин | 1,494,374,956.23 | 1,772,099,426.53 |
| 210102 | Нэмэгдэл | 821,335,996.47 | 1,096,845,653.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 105,253,759.96 | 48,121,773.00 |
| 210104 | Урамшуулал | 57,780,300.00 | 61,510,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 52,557,700.00 | 60,487,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 750,587.72 | 253,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 88,246.00 | 29,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 69,356.00 | 17,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,889.00 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 51,630,621.28 | 60,186,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 193,919,318.55 | 218,286,102.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 38,772,189.25 | 53,088,343.08 |
| 210302 | Түлш, халаалт | 139,845,837.00 | 144,922,305.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,301,292.30 | 20,275,454.84 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,087,300.00 | 16,042,930.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,827,900.00 | 1,061,190.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,456,400.00 | 8,590,090.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,207,300.00 | 1,087,350.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 2,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 1,320,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,395,700.00 | 1,984,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 109,331,400.00 | 158,359,872.00 |
| 210502 | Хоол, хүнс | 109,331,400.00 | 137,439,872.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 20,920,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 49,407,304.00 | 62,176,095.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 4,562,210.00 |
| 210604 | Урсгал засвар | 49,407,304.00 | 57,613,885.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,811,329.00 | 95,726,292.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,916,800.00 | 89,784,318.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 966,639.00 | 3,931,786.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 495,000.00 | 495,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,560,100.00 | 642,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 872,790.00 | 872,788.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 125,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 125,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 71,375,437.09 | 5,230,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,523,100.00 | 5,230,500.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 3,930,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,523,100.00 | 1,300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 65,852,337.09 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 65,852,337.09 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 26,960,000.00 | 41,055,000.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 26,960,000.00 | 41,055,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 26,960,000.00 | 41,055,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 26,960,000.00 | 41,055,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -26,960,000.00 | -41,055,000.00 |
| 145 | Бусад эх үүсвэр | | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***/төгрөгөөр/***

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Бусад цэвэр хөрөнгө/өмч | Хуримтлагдсан үр дүн | Хяналтын бус хувь оролцоо | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 509,506,709.69 | 400,010,490.78 | | 5,888,565,156.99 | | 6,798,082,357.46 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 3,290,009.00 | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 509,506,709.69 | 400,010,490.78 | | 5,888,565,156.99 | | 6,798,082,357.46 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | | |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | | -573,591,259.99 | | -570,301,250.99 |
| 10 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 509,506,709.69 | 400,010,490.78 | | 5,318,263,906.00 | | 6,227,781,106.47 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | | -894,900,592.27 | | -894,900,592.27 |
| 19 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 509,506,709.69 | 400,010,490.78 | | 4,423,363,313.73 | | 5,332,880,514.20 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

***/төгрөгөөр/***

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,580,679,700.00 | 3,448,720,300.00 | 131,959,400.00 | 96.31 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,580,679,700.00 | 3,448,720,300.00 | 131,959,400.00 | 96.31 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,580,679,700.00 | 3,448,720,300.00 | 131,959,400.00 | 96.31 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,580,679,700.00 | 3,448,720,300.00 | 131,959,400.00 | 96.31 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,448,720,300.00 | 3,448,720,300.00 | | 100 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,443,489,800.00 | 3,443,489,800.00 | | 100 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,978,577,053.08 | 2,978,577,053.08 | | 100 |
| 210101 | Үндсэн цалин | 1,791,952,100.00 | 1,772,099,426.53 | 19,852,673.47 | 98.89 |
| 210102 | Нэмэгдэл | 1,096,272,453.08 | 1,096,845,653.55 | -573,200.47 | 100.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,842,200.00 | 48,121,773.00 | -19,279,573.00 | 166.9 |
| 210104 | Урамшуулал | 61,510,300.00 | 61,510,200.00 | 100 | 100 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,487,800.00 | 60,487,800.00 | | 100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 253,700.00 | 253,700.00 | | 100 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,900.00 | 29,900.00 | | 100 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,300.00 | 17,300.00 | | 100 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,719,400.00 | | 2,719,400.00 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 57,467,500.00 | 60,186,900.00 | -2,719,400.00 | 104.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 216,442,532.92 | 216,442,532.92 | | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 53,088,343.08 | 53,088,343.08 | | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 144,922,305.00 | 144,922,305.00 | | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,431,884.84 | 18,431,884.84 | | 100 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,452,840.00 | 4,452,840.00 | | 100 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,061,190.00 | 1,061,190.00 | | 100 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,087,350.00 | 1,087,350.00 | | 100 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,320,000.00 | 1,320,000.00 | | 100 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 984,300.00 | 984,300.00 | | 100 |
| 2105 | Нормативт зардал | 107,159,600.00 | 107,159,600.00 | | 100 |
| 210502 | Хоол, хүнс | 107,159,600.00 | 107,159,600.00 | | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 49,320,800.00 | 49,320,800.00 | | 100 |
| 210604 | Урсгал засвар | 49,320,800.00 | 49,320,800.00 | | 100 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,924,174.00 | 26,924,174.00 | | 100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,982,200.00 | 20,982,200.00 | | 100 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,931,786.00 | 3,931,786.00 | | 100 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 495,000.00 | 495,000.00 | | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 642,400.00 | 642,400.00 | | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 872,788.00 | 872,788.00 | | 100 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 125,000.00 | 125,000.00 | | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 125,000.00 | 125,000.00 | | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,230,500.00 | 5,230,500.00 | | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,230,500.00 | 5,230,500.00 | | 100 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,930,500.00 | 3,930,500.00 | | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,300,000.00 | 1,300,000.00 | | 100 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,448,720,300.00 | 3,448,720,300.00 | | 100 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

***/төгрөгөөр/***

| Д/Д | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 187,346,345.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 187,346,345.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,299,290.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 81,230,390.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 77,816,665.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 187,346,345.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 146,291,345.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 146,291,345.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,843,570.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,843,570.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,590,090.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,590,090.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 51,200,272.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,280,272.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 20,920,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,855,295.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,562,210.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,293,085.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | |

| | | |
|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 68,802,118.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 68,802,118.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 41,055,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 41,055,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 41,055,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 187,346,345.00 |

## 3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны чиг үүргийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь эрхэм зорилгоо “Гамшгаас хамгаалах, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхойлон дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд стандартыг мөрдөж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, нэгдсэн мэдээллийн санг баяжуулах;
- Алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийн дээшлүүлэн ёс зүй сахилга хариуцлагыг сайжруулах.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

## 5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулах журмыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид шагнал олгох” журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх талаар анхаарах.

Дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Дараагийн аудитаар шинээр хүлээн авсан тээврийн хэрэгслүүдийн бүртгэл хөтлөлт, холбогдон гарах зардлын зарцуулалт, ашиглалтыг нарийвчлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 6. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13,994.2 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрсэнд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 13,994.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 7. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулахдаа үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлэн 9,432.0 мянган төгрөг олгосон байна. | 1 | 9,432.0 | | | | | 1 | 9,432.0 | | | | |
| Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.3.тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх заалтыг зөрчиж төхөөрөмж худалдан авсан байна. | 1 | 4,562.2 | | | | | 1 | 4,562.2 | | | | |
| Дүн | 2 | 13,994.2 | | | | | 2 | 13,994.2 | | | | |